

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 07 ДУГААР САРЫН
НЭГ ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН ТОВЧ МЭДЭЭ

| Д/Д | Товч мэдээ | Бусад |
|-----|---|-------|
| 1 | Толбо нуурын эрэг дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага болон иргэдийн завь ашиглалт, авран хамгаалагч болон усан замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс хяналт шалгалт хийж, "Толбо Тур" ХХК-ийн эзэмшилд байгаа 2 ширхэг моторын завьний үйл ажиллагааг шалгаж зөрчил арилгуулах албан шаардлага өгч, түр хугацаагаар зогсоож, лац тавьж ажиллалаа. | |
| 2 | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 96 Жилийн ойн баярыг тохиолдуулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх Газрын даргын ажлын хэсгийн тушаал гаргалаа. | |
| 3 | "Зост-Өлгий" хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 17 заалт бүхий улсын байцаагчийн албан даалгавар өгч ажиллалаа. | |
| 4 | Толбо-Хашаатын чиглэлийн авто замын барилга угсралтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж байна. | |
| 5 | Хурим найрын үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын нэвтрүүлэг бэлдэж гаргалаа. Мөн илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч ажиллаж байна. | |
| 6 | Аймгийн Хүүхэд залуучуудын парк дээр цахилгаан бүхий тоглоом, цахилгааны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хугацаат албан шаардлага хүргүүлэн, зөвлөмж өгч ажиллалаа. | |
| 7 | "Хийн баллоны аюулгүй байдал, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа"-ны талаар шингэрүүлсэн шатдаг хийгээр хангагч байгууллагуудтай хамтран ард иргэдэд зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүллээ. | |
| 8 | Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгах тухай газрын даргын албан тоотыг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ. | |
| 9 | Аймгийн Төвд үйл ажиллагаа явуулж буй лифт, автокран, барилгын өргүүр бүхий бүх аж ахуйн нэгж байгууллагуудын өргөх механизмуудын аюулгүй байдлыг хангах талаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. | |
| 10 | Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн улсын байцаагч "Жимс, хүнсний ногоо импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдаалах үед анхаарах зүйлс"-ийн талаар ард иргэдэд мэдээллээ. | |